

UCS 2103A:2020

# ГУДАМЖ, ЗАМ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ




Гудамжны нэрийн тэмдэг байрлуулах,  
суурилуулах удирдамж



# ГУДАМЖ, ЗАМ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ

Гудамжны нэрийн тэмдэг байрлуулах,  
суурилуулах удирдамж



## ГАРЧИГ

1. Зорилго .....	1
2. Хамрах хүрээ .....	1
3. Норматив эшлэл.....	1
4. Нэр томъёоны тодорхойлолт.....	1
5. Төрөл ангилал .....	2
6. Ерөнхий шаардлага.....	3
7. Байрлуулахад тавигдах ерөнхий шаардлага .....	7
8. Суурилуулах .....	9
9. Материалын шаардлага .....	10
10. Бүртгэл, ашиглалт, засвар үйлчилгээ .....	11
11. Хүлээн авах шалгуур үзүүлэлт .....	12
Ашигласан материалын жагсаалт .....	13

### ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Урьдчилсан чигийн заалт тэмдэг .....	4
Зураг 2. Нэрийн тэмдгийн суурь болон бичиглэлийн өнгө.....	4
Зураг 3. Гудамжны нэрийн бичвэр, латин хөрвүүлэг жишээ.....	5
Зураг 4. Урт нэртэй гудамжны нэрийн жишээ.....	5
Зураг 5. Гудамжны нэмэлт тэмдэг суурилуулах тэмдгийн жишээ .....	5
Зураг 6. Самбар болон бичвэрийн хэмжээ .....	6
Зураг 7. Олон нэр байршуулах загвар .....	7
Зураг 8. Бага гудамжтай уулзварт нэрийн тэмдэг байрлуулах жишээ.....	8
Зураг 9. Тэмдэг хоорондын холбоос .....	9
Зураг 10. Авто замын зорчих хэсэгт суурилуулах чигийн урьдчилсан заалтын тэмдэг ..	9

### ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Нэрийн бичвэрт ашиглах товчлол .....	4
Хүснэгт 2. Гудамжны нэрийн тэмдгийн хэмжээ.....	6
Хүснэгт 3. Гудамжны нэрийн тэмдгийн харагдах байдал .....	8
Хүснэгт 4. Хүлээн авах шалгуур үзүүлэлт .....	12

## ГУДАМЖ, ЗАМ, БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ХАЯГЖИЛТ

### Гудамжны нэрийн тэмдэг байрлуулах, суурилуулах удирдамж

#### 1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь гудамж зам талбайн нэрийн тэмдгийг үйлдвэрлэх, шалгаж хүлээн авах, суурилуулах, байрлуулах ажлын ерөнхий шаардлагыг тодорхойлж, хотын оршин суугчид болон гадаад дотоодын жуулчид, явганаар болон авто замаар зорчигчдод мэдээлэл өгөх, орчны аюулгүй байдлыг хангахад оршино.

#### 2. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү баримт бичгийг гудамж, зам, талбайн нэршлийг тодорхойлох, нэрийн тэмдгийг үйлдвэрлэх, байршуулах, суурилуулах, орчны аюулгүй байдлын хяналт хийх үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

#### 3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах эш татсан барилгын норм ба дүрэм, стандартыг хэрэглэнэ. Эш татсан дараах баримт бичгүүдэд өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн хамгийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ.

БНБД 32-04-06 Хот тосгоны гудамж, зам төлөвлөлт

БД 31-112-11 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм

БД 30-102-11 Хот тосгон ба суурин газрын гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг төлөвлөх MNS 6775:2019 Хаяг. Хаягийн бичвэрт тавих шаардлага

MNS 5217:2012 Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг

MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм

#### 4. НЭР ТОМЬЁНЫ ТОДОРХОЙЛОЛТ

**Хаягжуулах** – гэж гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг зохион байгуулах, үл хөдлөх эд хөрөнгөд дугаар олгох, хаягийн мэдээллийн санд бүртгэх, хөтлөх, өөрчлөх, хүчингүй болгох, хаягийн зураг зохиох, хаягийн тэмдгийг стандартын дагуу үйлдвэрлэх, байршуулах цогц үйл ажиллагааг;

**Гудамжны нэрийн тэмдэг** – гэж зөвхөн нэр нь бичээстэй тэмдгийг;

**Өргөн чөлөө** – гэж 4 буюу түүнээс дээш урсгалтай авто зам, өргөн зай талбарыг;

**Гудамж** – гэж эгнэсэн хашаа барилга түүний завсрын шулуун чөлөө, 2 буюу түүнээс дээш урсгалтай авто замыг;

**Талбай** – гэж хотын гудамж, өргөн чөлөөтэй холбогдсон олон нийтийн зориулалттай орон зайг;

**Зам** – гэж замын аль нэг талаараа бүрэн барилгажаагүй, нэг суурьшлыг нөгөө суурьшилтай холбосон бол **замыг**;

**Чигийн урьдчилсан заалт** – гэж суурин газар буюу бусад объектод хүрэх чигийг урьдчилан мэдээлэх тэмдгийг;

**Тууш зам** – гэж эсрэг хөдөлгөөний зорчих хэсгүүд нь хоорондоо тусгаарлах зурвас, эсхүл замын хашилтаар зааглагдсан бөгөөд бусад зам болон явган хүний зам, унадаг дугуйн зам, мөн төмөр замтай нэг түвшинд огтлолцоогүй, 5.1 тэмдэг бүхий замыг;

## 5. ТӨРӨЛ АНГИЛАЛ

5.1. Гудамж, талбайг нэршүүлэхдээ тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр нь дараах байдлаар ангилна.

5.1.1. Дөрөв буюу түүнээс дээш урсгалтай авто замыг **өргөн чөлөө**;

5.1.2. Хоёр буюу түүнээс дээш урсгалтай авто замыг **гудамж**;

5.1.3. Хотын гудамж, өргөн чөлөөтэй холбогдсон олон нийтийн зориулалттай орон зайг **талбай**;

5.1.4. Замын аль нэг талаараа бүрэн барилгажаагүй, нэг суурьшлыг нөгөө суурьшилтай холбосон **зам**;

гэх мэтээр ангилдаг.

## 6. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 6.1. Хот, суурин газрын гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох санал боловсруулах үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн төлөөллөөс бүрдсэн 9-11 хүний бүрэлдэхүүнтэй орон тооны бус комиссыг нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулна (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам 2.1).
- 6.2. Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулахад дараах зарчмыг баримтална. Үүнд:
- Байр зүйн зурагт суурилсан байх;
  - Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарьт нийцсэн байх;
  - Хаяг давхардахгүй байх;
  - Хаяг үнэн зөв, энгийн, ойлгомжтой байх;
  - Кадастрын бүртгэлээр баталгаажсан байх;
  - Хаягжуулах ажил нэгдсэн арга зүйтэй байх;
  - Хаягийн талаарх мэдээлэл хүртээмжтэй, нээлттэй байх (Хаягжуулалтын тухай хууль 3.1).
- 6.3. Гудамж, талбайн нэрийг Монгол Улсын тусгаар тогтнол, хөгжил дэвшилд гарамгай гавьяа байгуулсан түүхэн хүмүүсийн нэр алдрыг мөнхлөх, түүх, соёлын дурсгал, түүхэн уламжлалыг хадгалахад чиглэсэн болон олон нийтээс санал болгосон, утга агуулгын хувьд уялдаатай, энгийн, ойлгомжтой нэр үгээр нэрлэнэ (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам 2.7).
- 6.4. Гудамж, зам, талбайг давхардахгүй байдлаар нэрлэж, дугаарлах бөгөөд хаягжуулах ажлыг улс, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ (Хаягжуулалтын тухай хууль).
- 6.5. Тухайн шатны Засаг дарга гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээг байрлуулах ажлыг хариуцан зохион байгуулна (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам 8.2).
- 6.6. Гудамж, замын нэрийн тэмдэг нь нэр болон дугаарыг багтаасан тэгш өнцөгт хэлбэртэй байна (Вений конвенц, 17 дугаар зүйл).
- 6.7. Тууш замд байрласан тэмдэгт тууш замаас өөр замаар явж хүрэх суурин газар буюу объектын нэрийг цэнхэр дэвсгэртэй оруулга дээр, харин суурин газрын дундуур дайран гарсан тууш замын хэсэг дээр байрлуулсан тэмдэгт уг суурин газрын нэрийг цагаан дэвсгэртэй оруулга дээр бичнэ (Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм 5.6).
- 6.8. Суурин газрын гаднах бусад замд байрласан тэмдэгт тууш замаар явж хүрэх суурин газар буюу объектын нэрийг ногоон дэвсгэртэй оруулга дээр бичнэ. Суурин газрын дотор байрласан тэмдэгт тууш замаар явж хүрэх суурин газар буюу объектын нэрийг ногоон дэвсгэртэй оруулга дээр, харин уг суурин газраас гарч бусад замаар явж хүрэх бол цэнхэр дэвсгэртэй оруулга дээр тус тус бичнэ (Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм 5.6).

6.9. Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэмд зааснаар чигийн урьдчилсан заалт 5.33.а-5.36 тэмдэг нь тууш замд байрласан бол ногоон, суурин газрын гаднах бусад замд байрласан бол цэнхэр, суурин газарт байрласан бол цагаан өнгийн дэвсгэртэй байна (Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм 5.6).



Зураг 1. Урьдчилсан чигийн заалт тэмдэг

6.10. Гудамжны нэрийн тэмдэг нь цагаан өнгийн суурин дээр хар өнгийн бичиглэлээр бичих бөгөөд хар өнгийн хүрээтэй байна. MNS FED ST 595C:2016 Авто замын тэмдгийн өнгөний код. Техникийн шаардлага стандартын дагуу өнгийг сонгож тааруулна.



Зураг 2.Нэрийн тэмдгийн суурь болон бичиглэлийн өнгө

6.11. Гудамжны нэрийг бүтнээр бичих бөгөөд гудамж, зам, талбайн төрлийг дараах байдлаар нэрийн ард товчлон тэмдэглэнэ (MNS 6775:2019).

Хүснэгт 1. Нэрийн бичвэрт ашиглах товчлол

Гудамж, талбайн төрлүүд	Монгол товчлол	Гадаад утга	Гадаад товчлол
Өргөн чөлөө	ӨЧ	Avenue	AVE
Гудамж	ГД	Street	ST
Газар	ГЗ	Place	PL
Зам	ЗМ	Road	RD



- 6.12. Тэмдэгт дэх бичвэрийг хоёроос илүүгүй хэл дээр хийх бөгөөд (Вений конвенц, 2 дугаар бүлэг, 14 дүгээр зүйл) бичиглэлийг үндэсний хэл болон латин үсгээр хөрвүүлэн бичнэ.
- 6.13. Латин үсгийн хөрвүүлэг нь “MNS 5217:2012 Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг” стандартын шаардлагыг хангасан байна.



Зураг 3. Гудамжны нэрийн бичвэр, латин хөрвүүлэг жишээ

- 6.14. Гудамж, талбайн нэрийг түүхэн хүний нэрээр нэрлэсэн тохиолдолд нэрийг нь товчлон бичихгүй, овгийг товчилж болох бөгөөд нэрд орсон үг бүрийг том үсгээр эхлүүлэн бичнэ. Нэрд мэргэжил, мэргэжлийн зэрэг, цолыг оруулж болно. Жишээлбэл: “Л.Дандарын гудамж”, “Хатанбаатар Магсаржавын гудамж”, “Сүхбаатарын талбай” гэх мэт (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам 6.3).



Зураг 4. Урт нэртэй гудамжны нэрийн жишээ

- 6.15. Мухар гудамжтай тохиолдолд “гарцгүй” гэсэн тэмдгийг гудамжны нэрийн тэмдгийн доод талд нэмэлт тэмдэг болгон суурилуулах шаардлагатай. Авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөн гудамжны төгсгөлд мухар болох нөхцөлд “Монгол Улсын Замын хөдөлгөөний дүрмийн 1 дүгээр хавсралтын 5.30.а-5.30.в «Мухар зам»” тэмдгийн хамт хэрэглэнэ.



Зураг 5. Гудамжны нэмэлт тэмдэг суурилуулах тэмдгийн жишээ

6.16. Нэрийн тэмдгийн өндөр 340мм хэмжээтэй бөгөөд уртын хэмжээ нь нэрийн бичвэр дэх тэмдэгтийн тооноос хамааран 600-2000мм хүртэлх байх боломжтой.

Хүснэгт 2. Гудамжны нэрийн тэмдгийн хэмжээ

Тэмдгийн өндөр /мм/	Тэмдгийн өргөн /см/
<b>А</b>	<b>В</b>
340	600-2000
340	700
340	800
340	900
340	1000
340	1100
340	2000

6.17. Гудамжны нэрийн тэмдгийн бичвэр болон самбарын хэмжээг Зураг 6-д үзүүлэв. Гудамжны нэрийн бичвэрийн эхний үсэг нь 100мм, жижиг үсэг нь 80мм, гудамжны төрлийн товчилсон бичвэр 80мм байна. Бүх бичвэрийг Arial үсгийн фондоор бичнэ.



Зураг 6. Самбар болон бичвэрийн хэмжээ

## 7. БАЙРЛУУЛАХАД ТАВИГДАХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 7.1. Дүүргийн Засаг дарга гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийн хаягийн тэмдэглэгээг байрлуулах ажлыг хариуцан зохион байгуулах бөгөөд хаягжуулах үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, шаардагдах санхүүжилтийг зохих журмын дагуу улс, орон нутгийн төсөвт тусгуулна (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам 9.1).
- 7.2. Засаг захиргааны нэгжийн хил зааг, хаягийн мэдээллийг “Нутаг дэвсгэрийн засаг захиргааны нэгжийн хаягийг мэдээлэх самбар”-т тусгаж, олон улс, улсын чанартай авто замыг дайран өнгөрөх байрлалд Хаягжуулалтын тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан журам, стандартад нийцүүлэн байрлуулна (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам 8.4).
- 7.3. Замын тэмдэг, тэдгээрээс өгч байгаа мэдээлэл нь зөвхөн тухайн хөдөлгөөнд оролцогчдод чиглэсэн байх нөхцөлийг хангана (MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм, 3.2).
- 7.4. Чигийн урьдчилсан заах тэмдгийн зааж буй чигт хэд хэдэн газар, суурин байгаа бол нэрсийг нэг нэгнийх нь дор байрлуулна (Венийн конвенц, 16 дугаар зүйл).



Зураг 7. Олон нэр байршуулах загвар

- 7.5. Замын тэмдэг болон хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгсэлтэй андуурагдах, тэдгээрийн үзэгдэлт ба үр дүнг бууруулах, хөдөлгөөнд оролцогчдыг гялбуулах, тэдний анхаарлыг сарниулах, улмаар хөдөлгөөний аюулгүй байдлыг алдагдуулах ямар нэгэн үзүүлэн чимэглэлийн зүйл, зар сурталчилгааны самбар, техник төхөөрөмж зэрэг хэрэгслийг авто замын зурвас газарт байрлуулахыг хориглоно (MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм, 3.1).
- 7.6. Замын тэмдэг, гэрлэн дохио, тэдгээрийн тулгуур дээр буюу ар талд хөдөлгөөний зохион байгуулалтад үл хамаарах бусад зүйл байрлуулахыг хориглоно (MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм, 3.1).

- 7.7. Замын тэмдгийг тусгайлан зааснаас бусад тохиолдолд зорчих хэсгийн баруун гар талд (хөвөөтэй бол түүний гадна) буюу зорчих хэсгийн дээр байрлуулна (MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм, 4.1.4).
- 7.8. Замын тэмдгийн үзэгдэлтийн зай 100 метрээс багагүй байвал зохино (MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм, 4.1.3).


*Хүснэгт 3. Гудамжны нэрийн тэмдгийн харагдах байдал*

Зорчих хурд /км/цаг/	Харагдах зай /метр/
60	85
70	100
80	120
90	140
110	180


- 7.9. Авто замын зорчих хэсэгт гудамжны нэрийн тэмдгийг байрлуулахдаа дараах нөхцөлийг харгалзан үзэх бөгөөд “MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” стандартын шаардлагыг хангасан байна.

Гудамжны нэрийг дараах зурагт үзүүлсэн байдлаар байрлуулна (Зураг 8).


4 замын уулзварт 2 гудамж  
огтлолцох үед огтлолцож  
байгаа тал бүрд



3 замын уулзварт 3 гудамж  
уулзах үед уулзаж байгаа  
тал бүрд



4 замын уулзварт 4 гудамж  
уулзах үед уулзаж байгаа  
тал бүрд




*Зураг 8. Бага гудамжтай уулзварт нэрийн тэмдэг байрлуулах жишээ*

- 7.10. Чигийн урьдчилсан заалтын тэмдгүүдийг зам ба хөдөлгөөний нөхцөл, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний хурд, тэмдгийг харах зай зэргийг тооцон тухайн уулзвараас өдөр, шөнийн аль ч цагт хамгийн сайн харагдахуйц зайд байрлуулах ёстой. Энэ зай нь суурин газарт 50 метрээс илүүгүй, харин тууш зам ба хурдны замд 500 метрээс багагүй байвал зохино (Вений конвенц, 2 дугаар бүлэг, 15 дугаар зүйл).


## 8. СУУРИЛУУЛАХ

8.1. Гудамжны нэрийн тэмдэг нь бие даасан шонд суурилуулах бөгөөд 2-оос дээш нэрийн тэмдэг байршуулах шаардлагатай бол дараах холбоосын ашиглана.  
/Зураг 9/



Зураг 9. Тэмдэг хоорондын холбоос

- 8.2. Авто замын зорчих хэсэгт чигийн урьдчилсан заалтын тэмдэг суурилуулахдаа “MNS 4596:2014 Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм” стандартын дагуу хийж гүйцэтгэнэ.
- 8.3. Нэрийн тэмдгийг авто замтай перпендикуляр байхаар харуулж суурилуулна.



Зураг 10. Авто замын зорчих хэсэгт суурилуулах чигийн урьдчилсан заалтын тэмдэг

## 9. МАТЕРИАЛЫН ШААРДЛАГА

- 9.1. Гудамжны нэрийн тэмдгийн хэвлэх материал /хуулга/ нь шөнийн тээврийн хэрэгслийн болон бусад төрлийн гэрлийн тусгалаар гэрэлтдэг байх шаардлагатай. Гэхдээ энэ нь хөдөлгөөнд оролцогчдыг гялбуулахааргүй байна.
- 9.2. Гудамжны нэрийн тэмдэг хэвлэх материал нь MNS FED ST 141:2015 Авто замын тэмдгийн гэрэл ойлгогч болон будаг, лак зэрэг өнгөлгөөний бусад материалын чанар тавих хяналт, дээж авах, туршилт хийх арга стандартын шаардлагын дагуу хийгдсэн байна. Үүнд:
- 9.2.1. Гэрэл ойлгогч хуулганы төрөл А (дундаж цацралттай) - Engineer Grade Prismatic (EGP)




Энэхүү материалыг ихэвчлэн хөдөлгөөн багатай, бага хурдтай, гэрлийн өрсөлдөөн багатай газарт ашигладаг.

Түгээмэл хэрэглэгддэг тэмдэг нь зогсоолын тэмдэг болно.

Standard: ASTM Type I

- 9.2.2. Гэрэл ойлгогч хуулганы төрөл Б (өндөр цацралттай) – High Intensity Prismatic (HIP)




Энэхүү материал нь дээрх материалтай харьцуулбал 4 дахин илүү гэрэл ойлгох чадвартай.

Ихэвчлэн ашигладаг тэмдэг нь анхааруулах тэмдэг бөгөөд зогс тэмдэг, хурдны хязгаар, явган хүний гарц тэмдэг болно.

Standards: ASTM Type III, ASTM Type IV

- 9.2.3. Гэрэл ойлгогч хуулганы төрөл В (хэт өндөр цацралттай) - Diamond Grade (DG3)



Энэхүү материалыг цаг агаарын бүх нөхцөл байдалд замын хөдөлгөөнд оролцогчид бүгд харах ёстой гэж үзсэн тэмдгийг хийхэд ашигладаг байна.

Ихэвчлэн ашигладаг тэмдэг нь хурдны замын тэмдэг, сургуулийн бүс, гудамжны нэрийн тэмдэг, зогс тэмдэг болно.

Standards: ASTM Type IX, ASTM Type XI

#### 9.2.4. Хамгаалах давхар хуулга - Protective Overlay Film (POF)



Энэхүү материалыг замын тэмдгийг байгаль цаг уурын болон механик гэмтлээс хамгаалж эдэлгээг уртасгах зорилгоор ашиглаж байна.

9.3. Тэмдгийн самбар нь хөнгөн цагаан металлаар хийгдэх бөгөөд ирмэг хэсгийг эргүүлэн нугалсан байна.

### 10. БҮРТГЭЛ, АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

10.1. Хаягийн тэмдэглэгээний бүрэн бүтэн байдлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцна (Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоол, Гудамж, зам, талбай, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах журам 8.5).

10.2. Гудамж, зам талбай, авто замын зорчих хэсэгт байрлуулсан тэмдгийг тухайн шатны Засаг даргын хариуцагчаар томилсон байгууллага бүртгэх бөгөөд “UCS 1401A Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайд байрлуулсан эд хөрөнгийн бүртгэл, ашиглалтын удирдамж”-ийг мөрдлөг болгоно.

## 11. ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Гудамжны нэрийн тэмдэг нь түүнд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хүлээн авах шалгуур үзүүлэлтийг Хүснэгт 4 -ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

*Хүснэгт 4. Хүлээн авах шалгуур үзүүлэлт*

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Гудамжны нэр нь албан ёсны баталгаажсан нэр мөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Гудамжны нэрийн тэмдгийн самбар нь стандартын шаардлагын дагуу хэмжээтэй байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Гудамжны нэрийн тэмдгийн бичвэр нь стандартын шаардлагын дагуу хэмжээтэй байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Гудамжны нэрийн тэмдгийг байрлуулахдаа Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм болон бусад хууль тогтоомжийн дагуу байрлуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Гудамжны нэрийн тэмдгийн бичвэр нь үг үсгийн алдаагүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Гудамжны нэрийн тэмдгийн материал нь гэрлийн ойлт болон харагдах байдлын шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Тэмдгийг суурилуулалт бэхэлгээ шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

### **Тайлбар:**

- Төрийн байгууллагын төлөвлөлт нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.



## **АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ**

- Замын дохио, тэмдгийн тухай Вений конвенц
- Монгол Улсын үндсэн хууль
- Хаягжуулалтын тухай
- Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль;
- Монгол Улсын замын хөдөлгөөний дүрэм;
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам /Засгийн Газрын 2019 оны 325 дугаар тогтоол/;
- Америкийн нэгдсэн улсын Кансас хотын Гудамжны тэмдэг, суурилуулах, байрлуулах заавар /2013 он/
- Австрали улсын Велингтон хотын гудамжны нэрийн тэмдэг суурилуулах заавар /2001 он/
- MNS 4596:2014 Замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм
- MNS FED ST 141:2015 Авто замын тэмдгийн гэрэл ойлгогч болон будаг, лак зэрэг өнгөлгөөний бусад материалын чанар тавих хяналт, дээж авах, туршилт хийх арга
- MNS FED ST 595 C:2016 Авто замын тэмдгийн өнгөний код. Техникийн шаардлага







Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг  
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН  
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



[www.standart.ub.gov.mn](http://www.standart.ub.gov.mn)



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,  
зохицуулалтын газар